



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

05.04 - 05.08



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Коронвирусийн эсрэг эмчилгээний боломжуудад ахиц гарсан болон дэлхийн эдийн засгууд хэсэгчлэн нээгдэж байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл нэмэгдэж, энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Технологийн салбарын компаниудыг илүүтэйгээр агуулдаг NASDAQ индекс энэ оны эхэн үетэй харьцуулахад өсөлттэй байгаа ба бүх цаг үеийн хамгийн өндөр түвшнээс дөнгөж 7% бага байна. S&P500 индексийн сагсанд багтах Apple компанийн хувьцааны ханшийн өсөлтөөс үүдэн технологийн салбар хамгийн их өсөлттэй байлаа. Мөн, АНУ-ын газрын тосны нөөцтэй холбоотой эрчим хүчний салбар өсөлттэй байлаа. Харин ус цахилгаан дулааны салбар болон өргөн хэрэглээний бараа үйлчилгээний салбар бууралттай байлаа.

АНУ-ын шинээр ажилгүй гэж бүртгүүлсэн иргэдийн тоо хүлээлтээс өндөр байсантай холбоотойгоор ЗГҮЦ-ны өгөөж бага зэрэг буурсан ч, Холбооны Нөөцийн Сангийн урт хугацаат өрийг бонд гаргаж төлөхөөр шийдвэрлэсэн нь урт хугацаат бондын гаргалтыг нэмэгдүүлж, өгөөж өсөхөд нөлөөлсөн байна. Шинжээчид Холбооны Нөөцийн Сангаас богино хугацаат хүүгийн түвшнийг 0%-аас бууруулахгүй гэж таамаглаж байгаа ч, зах зээлийн оролцогчид дараа жил сөрөг хүүгийн түвшинтэй болно гэсэн хүлээлттэй арилжаа хийж байгаа нь илт байна гэжээ.

Европ: АНУ болон БНХАУ-ын худалдааны дайны хурцадмал байдал суларч, эдийн засгууд хэсэгчлэн нээгдсэнтэй холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан байна. STOXX Europe 600 индекс 0.92%, DAX индекс 0.24% тус тус өссөн бол CAC 40 индекс 0.59%, FTSE MIB индекс 1.84% бууралт үзүүлсэн байна. БНХАУ-ын экспортын хэмжээний огцом өсөлттэй холбоотой дэлхийн эдийн засаг харьцангуй хурдан сэргэх найдлага төрж, Их Британийн FTSE 100 индекс 3% өссөн байна.

Европын Комиссын сүүлийн үеийн таамаглалаараа, коронавирусийн цар тахлаас шалтгаалж евро бүсийн эдийн засаг 2020 онд түүхэнд байгаагүй их хэмжээгээр буюу 7.75%-аар агшихаар байгаа ч 2021 онд сэргэж 6.25% өсөлт үзүүлнэ гэсэн байна. Харин Европын Холбооны улсуудын эдийн засаг 2020 онд 7.5%-аар агшиж, 2021 онд 6%-аар тэлэх таамаглал гаргаад байна. Европын Холбооны болон Евро бүсийн улсуудын эдийн засгийн өсөлтийн таамаг 2019 оны намраас 9 орчим хувиар буураад байна.

Япон: Япон улсын үндэсний амралтын өдөр таарсан энэ долоо хоногт хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Nikkei 225 Stock Average индекс 560 пункт буюу 2.9% өсөлт үзүүлж 20,179.09 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 14.7% бага байгаа юм.

БНХАУ: БНХАУ-д 4-р сарын 30-наас энэ Лхагва гараг хүртэл бүх нийтийн амралтын өдөр байсан байна. Shanghai Composite индекс, CSI 300 large-cap stock индекс аль аль нь 1.25% өсөлт үзүүлжээ.

Иргэдийн эрүүл мэндийн нөхцөл байдал харьцангуй сайжирч, бүх нийтийн амралтын өдрүүдэд ердөө 2 шинэ коронавирусийн тохиолдол бүртгэгдсэн байна. Мөн Үндэсний Ардын Их Хурал 5-р сарын 21-ээс 5000 гаруй төлөөлөгчидтэйгөөр хуралдахаар болсон байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,539.45	0.19% ▲
Dow Jones	АНУ	24,331.32	2.56% ▲
S&P 500	АНУ	2,929.80	3.50% ▲
Nasdaq	АНУ	9,121.32	6.00% ▲
S&P/TSX	Канад	14,966.56	2.37% ▲
FTSE 100	Их Британи	5,935.98	3.00% ▲
S&P/ASX 200	Австрали	5,391.10	2.77% ▲
Nikkei 225	Япон	20,179.09	2.85% ▲
Hang Seng	Хонг Конг	24,230.17	-1.68% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	95.21
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	88.43
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	88.84
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	98.57
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.63
DBM' 2023	USD	7.250%	87.01
TDBM' 2020	USD	9.375%	99.86
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	78.52

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.198	-0.11 ▼
Libor 3M	0.435	-0.11 ▼
Libor 6M	0.688	-0.03 ▼
Libor 1YR	0.783	-0.05 ▼
US 2YR Bond	0.159	-0.03 ▼
US 3YR Bond	0.215	-0.02 ▼
US 5YR Bond	0.340	-0.01 ▼
US 10YR Bond	0.694	0.08 ▲

Валютын ханш	2020.05.08	Өөрчлөлт
USD	2,791.49	0.09% ▲
CNY	394.47	-0.11% ▼
EUR	3,026.11	-1.04% ▼
RUB	37.80	2.11% ▲
KRW	2.29	0.44% ▲
JPY	26.24	0.61% ▲
CAD	2,001.64	0.75% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,702.70	0.13% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.48	3.37% ▲
Зэс	USD/lb.	240.60	4.07% ▲
Нүүрс	USD/MT	54.23	1.94% ▲
WTI газрын тос	USD/bbl.	24.74	25.08% ▲
Brent газрын тос	USD/bbl.	30.97	17.13% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. III	6.4%
Бодлогын хүү	2020. III	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. III	10.18%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. III	11.41%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. III	4.67%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. III	17.07%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. III	10.34%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 33 компанийн 1,996.2 сая төгрөгийн 16,849,309 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Таван толгой” /TTL/ компанийн хувьцаа 10.70%-аар буюу хамгийн ихээр өсөж 5,535.00 төгрөг хүрч хаагдсан бол “Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 8.89%-аар буурч 820.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

05-р сарын 08-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,456.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16539.45 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.19%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,996.2	
Зах зээлийн үнэлгээ	2,456,742.3	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,539.45	0.19% ▲
MSE I индекс	7,867.87	1.98% ▲
MSE II индекс	7,436.56	-0.96% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Монос хүнс	10,074,313	830,877,240
Монгол шуудан	1,000,000	600,000,000
Ард кредит ББСБ	3,923,112	314,615,958
Ард санхүүгийн нэгдэл	56,300	82,247,077
Лэндмн ББСБ	1,205,223	40,875,559

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Таван толгой	5,535.00	10.70% ▲
Баянгол зочид буудал	32,860.00	6.00% ▲
Женко тур бюро	88.00	3.53% ▲
Нэхээсгүй эдлэл	2,400.00	2.56% ▲
Говь	204.50	1.91% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	820.00	-8.89% ▼
Дархан гурил тэжээл	3,300.00	-8.66% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корп	470.00	-7.48% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,391.00	-7.27% ▼
УБ-БҮК	399.00	-5.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	2,007,403,571
Голомт Капитал	1,663,447,498
Би Ди Сек	142,452,944
Стандарт Инвестмент	34,788,199
Бумбат-Алтай	27,933,814

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	542.82	577,659
Таван толгой	5,535.00	291,502
МИК Холдинг	11,000.00	227,803
Инвекор ББСБ	2,550.00	182,906
Говь	204.50	159,533

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 5-р сарын 05-ны өдөр аудитын болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд хийх сургалтыг “Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт”, “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт”, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн арилжааны зуучлагчийн арилжаанд оролцогч брокерийн сургалтыг “Хөдөө, аж ахуйн гаралтай бараа түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо”-д сургалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар гэрээг тус тус байгууллаа.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компанийн 72% нь хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийв

Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаат компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн 5-р сарын 1-ний дотор зарлан хуралдуулах үүрэгтэй байдаг.

Энэ жилийн хувьд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудаас 143 хувьцаат компани буюу 72% нь ХЭХ-аа хуралдуулаад байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй ижил байгаа юм.

Заасан хугацаанд хурлаа хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болдог ба 2019 онд СЗХ-оос нэр бүхий 53 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг дуусгавар болгож байсан юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Тахь-Ко” ХК-ийн 2019 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Тахь-ко” /MSE: ТАН/ ХК нь 2019 онд нэгж хувьцаандаа 97 төгрөг 20 мөнгө тараасныг 2020 оны 05-р сарын 04-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв

“Лэндмн ББСБ” ХК нээлттэй хүрээнд бонд гаргана.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК олон нийтэд бонд гарган арилжаалах шийдвэрийг ТУЗ-өөс гаргасан байна.

Үүнээс өмнө тус компани хаалттай хүрээнд хэд хэдэн удаа бонд гаргаж байсан бөгөөд энэ удаагийн бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгийг зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах аж.

Бонд гаргах үйл ажиллагааны ерөнхий андеррайтераар өмнө нь IPO гаргахад хамтран ажиллаж байсан “Мирэ Эссэт Секьюритис Монгол” ҮЦК болон “Ард капитал групп” ҮЦК-ийг сонгосон байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Тавантолгой” ХК ногдол ашиг тараахаар боллоо.

“Тавантолгой” /MSE: TTL/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн № 04 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 821 төгрөг буюу 43.2 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2020 оны 4-р сарын 03-ны өдрөөр тогтоох бөгөөд 2020 оны 5-р сарын 31-ний дотор “ҮЦТХТ” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Азийн хөгжлийн банк COVID-19-ийн эсрэг бэлэн байдал, хариу арга хэмжээг дэмжих зорилгоор Монгол Улсад хэрэгжүүлж буй эрүүл мэндийн салбарын төсөлд 30 сая ам.долларын нэмэлт санхүүжилт баталлаа.

Нэмэлт санхүүжилтээр улсын хэмжээний хоёр болон гурав дахь шатлалын эмнэлгүүдийн ариутгал халдваргүйжүүлэлтийн тасгуудыг шинэчилж, эмнэлгүүдийн COVID-19 халдварыг оношлох, эмчлэх чадавхыг сайжруулах юм байна. Монгол Улсын Засгийн газар 772 мянган хүн буюу хүн амын 20 хув нь COVID-19-ийн халдварын өндөр эрсдэлтэйд тооцож байгаа тухай хэвлэлийн мэдэгдэлд дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Олон Улсын Валютын Сангийн тооцооллоор цар тахлын дараах ирэх 20 жилд дэлхийн хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтад 20 их наяд ам.доллар шаардлагатай байна.

Дийлэнх нэмэлт хөрөнгө оруулалтыг эрүүл мэндийн систем, дэд бүтэц, ногоон технологид зарцуулахыг зөвлөжээ. Эн тэргүүнд цар тахлын аюул өнгөрмөгц хэрэгжүүлэх төслийн хөрөнгө оруулалтыг одоогоос төлөвлөх хэрэгтэйг анхааруулсан байна. Үүний зэрэгцээ төслийн менежмент, хяналтаа сайжруулах шаардлагатай аж. Учир нь сул менежментийн улмаас дэлхийн хэмжээнд нийтийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын гуравны нэг нь үр ашиггүй зарцуулагдаж байна гэж тайланд дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхний дөрвөн сард ноолуурын экспорт өмнөх оны үеэс 86.3 хувиар эрс буураад байна. Ноолуур бэлтгэлийн гол улирал болох 4-р сараас өмнө энэхүү үзүүлэлт 69 хувиар өсөөд байв.

Хэдий тийм боловч "COVID-19" цар тахлын улмаас ноолуурын бэлтгэл ажил саатаж, эрэлт огцом буурсан байна. Эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих хоёр дахь багц арга хэмжээндээ Засгийн газар ноолуур худалдан авахад кг тутамд 20 мянган төгрөгийн урамшуулал олгохоор заагаад байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.